



**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 2/10

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/65 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/65 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Х.Батхүү)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Оргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны  
өдрийн 2/10 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Х.БАТХҮҮ

(НХОГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Т.БАТЗАЯА

(НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвийн менежер)

Т.УНДАРМАА

(НХОГ-ын Төлөвлөлт судалгааны хэлтсийн Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн)

Я.АЛТАНТУНГАЛАГ

(Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Э.ОРГИЛ

(НХОГ-ын Барилга захиалагчийн хэлтсийн Цахилгааны хяналтын инженер)